

ДУРСАМЖ

Ш. Бира*

Мянга есөн зуун дөчин зургаан оны хаврын нэгэн өдөр М. Дүгэрсүрэн, Аварзэд, Хосбаяр, Пүрэвжав, Лочин болон миний бие бүгд зургаан хөвгүүн анх удаа Монгол улсын Засгийн газар, МАХН-ын төв байранд яаралтай дуудагдан очив. Тэр үед бид бүгдээрээ Монгол улсын Их сургуулийн оюутнууд байв. Миний хувьд бол Их сургуулийн дэргэдэх хоёр жилийн бэлтгэл ангийг төгсгөөд тоо, физикийн жинхэнэ ангид суралцахаар болоод байсан юм. Манай бусад нөхөд бүгдээрээ Их сургуулийн хоёрдугаар ангийг амжилттай төгсгөөд байв. Дүгэрсүрэн мөн тоо, физикийн ангид суралцаж байв.

Бидний хэдэн оюутан нам, төрийн төв байранд дуудагдан цугларсан учир бол бидэнтэй маршал Х. Чойбалсан уулзаж нэг ёсны шалгалт, одоогийнхоор бол ярилцлага хийж биечлэн танилцах гэсэн байжээ. Х. Чойбалсан тэр үед Монгол улсын Ерөнхий сайд, Гадаад явдлын яамны сайдыг давхар хашиж байв. Биднийг мөнхүү яамны орлогч сайд Н. Лхамсүрэнгийн хамт хүлээн авч уулзсан билээ. Тэд биднийг нэг нэгээр нь дуудаж уулзахдаа намтар, хичээл сурлагын талаар асуун танилцахын хамтад мөн орос хэлээр асуулт тавьж ярилцаж бидний орос хэлний мэдлэгийг ч шалган үзэж байв. Эцэст нь тэд бидэнтэй уулзаж ярилцсныхаа тухай тайлбарлаж ярихдаа биднийг Гадаад явдлын яамны нэр дээр Москвад дээд сургуульд явуулж суралцуулах саналтай байгаагаа хэлж байв.


Хэдэн хоногийн дараагаар биднийг Москвагийн Олон улсын харилцааны дээд сургуульд явуулан суралцуулах болсон тухай албан ёсоор мэдэгдэв. Явахын өмнөхөн Дүгэрсүрэнг бидний ахлагчаар томилсон тухай Гадаад явдлын яамнаас мэдэгдэж бид ч алсын аяндаа мордов.

* Монгол улсын хөдөлмөрийн баатар, Академич

Бид ачааны машинаар Алтанбулаг хүрч улмаар хил нэвтрэн Оросын Наушкаас галт тэргэнд сууж арав гаруй хоног явж Москвад хүрэв. Замд явахаасаа эхлээд бидний хэдэн залуус хэрэг дээрээ Дүгэрсүрэн ахлагчийнхаа удирдлагад явсандаа.

Бидний дотроо Дүгэрсүрэн бол арай ахмад нь байсан төдийгүй урьд нь Буриадад рабфакт суралцаж байсан хийгээд Их сургуульд орохынхоо өмнө мөн багш байсан учир багагүй туршлагатай хашир суусан нэгэн байсан юм. Орос хэлдээ биднээс илүү сайн учир орос хүмүүстэй дороо хэл амаа олчихдог байв. Бид ч түүнийг их хүндэтгэнэ, үгийг нь дуулна. Үүнд ялангуяа нөхдийнхөө дотор хамгийн бага нь байсан миний бие Дүгэрсүрэнг анхнаасаа аваад их хүндэтгэн үзэж түүнтэй дотно нөхөрлөсөн билээ. Дүгэрсүрэн ч надад сайн болж ялангуяа миний хичээл номондоо аль болохоор хичээн зүтгэдгийг минь их сайшаан урамшуулдаг байж билээ. Ер нь одоо бодоход бидний зургаан оюутан хамт суралцах үедээ хоорондоо тун нөхөрсөг сайхан харилцаатай байж билээ. Бүгдээрээ л хичээл номын төлөө л мэрийн зүтгэдэг байв. Нэг нь ч энэ тэр элдэв болох бүтэхгүй асуудалд ордоггүй, сургуульдаа үлгэр жишээ сурагчдын тоонд ордог байж билээ. Дүгэрсүрэн бол хичээлээс гадуур спорт, ялангуяа волейбол их сонирхоно, тун сайн тоглоно. МГИМО-гийн шилдэг нэгдүгээр командад гол довтлогчоор тоглодог байсан. Биднийг сурч байхад Орос орны байдал туйлын хүнд байсан. Тэр үед дайн дөнгөж дуусаад байв. Амьдрал ч маш хэцүү байсан.

Бидэнд суралцахад хамгийн хэцүү хичээл бол гадаад хэл байсан. Дүгэрсүрэн, Хосбаяр, Лочин, Бира нар гол гадаад хэл болгон англи хэлийг, Аварзэд, Пүрэвжав нар франц хэлийг тус тус сонгон авсан. Манай сургууль гадаад хэлийг маш нарийн аргачлалаар тун сайн заадаг байсан. Зөвхөн англи хэлний фонетик гэхэд л үсэг бүрийн дуудлагыг хэдэн хоногоор тусгайлан зааж сургахдаа хэл, амны байрлалыг хүртэл толинд харуулан дасгал хийлгэж сургадаг байв. Үсэг бүрийн дуудлагыг хэрхэн сурсан талаар нэг бүрчлэн шүүлэг авдаг байв. Одоо бодоход энэ бол гадаад хэл заах шилдэг арга байжээ. Энэ учраас ч хожим англи хэлтэй хүмүүстэй ярихад бидний англи хэлний аялгуу болон дуудлагыг их сайн байна хэмээн магтдаг байв. Манай сургуулийн лингафоны кабинет тун сайн ажилладаг байсан бөгөөд тэнд бид төрөлхийн англи хэлтэн хүний дуудлага, аялгуу, хэл яриаг сонсож хичээллэдэг байв.



Дүгэрсэн, Хосбаяр, Аварзэд, Пүрэвжав нар олон улсын хууль зүй, Лочин, бид хоёр олон улсын харилцааны түүхийн ангид орж суралцав. Манай багш нар бол Москвагийн Их сургуулийн болон Шинжлэх ухааны Академи, Гадаад явдлын яамны шилдэг профессор, академич, мэргэжилтэн нар байв.

Бидний хэдэн монгол оюутны талаар орос хэл, утга зохиолын багш байсан доцент В.Н. Бабенко олон жилийн дараагаар 1996 онд гадаад оюунуудыг манай сургуульд анх бэлтгэж эхэлсний 50 жилийн ойгоор бичиж хэвлүүлсэн нэгэн дурсамж өгүүлэлдээ бичихдээ Оросын уран зохиолын талаар зохион явуулдаг семинар их сонирхолтой болдог байсан тухай дурьдаад тусгайлан тэмдэглэсэн нь: "... ном зохиолыг шүүн хэлэлцэхэд М.Дүгэрсүрэн (хожим БНМАУ-ын Гадаад хэргийн сайд агсан), Ш.Бира (академич болсон), Хосбаяр (Энэтхэгт элчин сайд байсан) гурав голдуу өрсөлддөг байв. Тэднийг хараад Аварзэд (БНМАУ-ын Ерөнхий прокурор байсан), Лочин (Египетэд элчин сайд байсан) нар зоригжин оролцоно. Харин Пүрэвжав (Алжирт элчин сайд байсан) тун тайван байдалтай маргааныг дүгнэнэ.

Би Дүгэрсүрэнгийн "1924 онд БНМАУ-ын үндсэн хуулийн эрх зүйн үндэс" гэдэг дипломын ажлыг одоо болтол дурсан санадаг. Энэ ажил нь бичлэгийн логик, найруулга болон нотолгоогоороо проф. И.А.Кирилинд их сэтгэгдэл төрүүлсэн гэдэг. Оросын уран зохиол Ш.Бирагийн орчуулгын авьяасыг хөндөн сэргээсэн бололтой. Тэрээр А.Островскийн "Гроза (Аянга)" хэмээх жүжгийн зохиолыг монгол хэлнээ орчуулан улмаар Улаанбаатарын театрт тавьж үзүүлжээ" (Из Истории МГИМО. Москва. 1997, стр 13).